

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДИЙН ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ОНЦЛОГ PRISONERS, THE ORGANIZATION OF LABOR AND REGULATORY TRADITIONS AND SPECIFIC REFORM



АЛхагва. ХСИС-ийн Шинжлэх ухаан, технологийн газрын Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн дарга бөгөөд Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын гавъяат хуульч, хууль зүйн доктор, профессор, хурандаа
Lhagva.A. Head of Court Decision Execution Studies center, Science and technology Department, Law Enforcement University Honored lawyer of Mongolia, Ph.D, Professor, Colonel

Abstract: Mongolian prisoners in Labor organization, based on the legal, regulatory historical traditions legal reform with analysis the organization of labor prisoners to further improve the legal regulation is proposed.

1. ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДИЙН ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Санаатай болон санамсар болгоомжгүйн улмаас гэмт хэрэг үйлдэж олон нийтээс тусгаарлагдан хорих ял эдэлж байгаа хүмүүсийг хүмүүжүүлэхэд нийгмийн тустай хөдөлмөрийн үр нөлөө асар их болохыг засан хүмүүжүүлэх байгууллагын (ЗХБ) түүхэн хөгжлийн явц харуулдаг билээ.

Хорих ял эдлүүлэх байгууллагын эрхлэх үйлдвэрийн чиглэл, байршилыг зөв тогтоож, хоригдлыг ажлаар хангахад төрөөс зохих анхаарал тавьж ирсэн нь энэ чиглэлээр удаа дараа гаргасан эрх зүйн баримт бичгийн агуулгаас тодорхой харагдаж байна. Эдгээрийн дотор түүхэн томоохон байр суурь эзлэх шийдвэр бол 1929 оны 6 дугаар сарын 14-нд Засгийн газрын есдүгээр хурал, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 55 дугаар хурлаар баталсан “Аливаа хэрэгтэн ялтнаар ажил үйлдвэрлэл хийлгэх тухай дүрэм” юм.¹⁵⁴

Засан хүмүүжүүлэх байгууллагын үйлдвэрлэл нь 50-иад оны эхэн үе хүртэл гар урлал, мал аж ахуй, газар тариалан эрхлэх, барилга барих, барилгын модон материал бэлтгэх, тоосго үйлдвэрлэх зэрэг чиглэлээр хөгжиж ирсэн байна.

ЗХБ-ын үйлдвэрлэлийн салбарыг нэмэгдүүлэх, гар ажиллагааг механикжуулах, хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх ажил 60-аад оноос нилээд эрчимжсэний нэг жишээ бол БНМАУ-ын СнЗ-өөс 1960 оны 3 дугаар сарын 2-ны өдөр “Засан хүмүүжүүлэх байгууллагын үйлдвэрлэлийн чиглэлийн тухай” 86 дугаар тогтоол гаргасан явдал юм.

1961 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хорих ял эдлүүлэх байгууллагууд нийт 21 төрлийн ажил үйлдвэрлэл эрхлэх болжээ. Тухайлбал: Гуалин, түлээ бэлтгэх, мод чирэх, мод ачиж буулгах, битон эдлэл хийх, Р-65 рамаар мод зүсэх, мужааны төрөл бүрийн ажил, оёдол эрхлэх, төмөр эдлэл хийх, арьс элдэх, өвс хадлан бэлтгэх, ногоо тариалах, барилгын суурийн чулуу бэлтгэх, гар аргаар туйлуу цохих, газар шорооны ажил хамрагджээ.

СнЗ-өөс 1963 оны 7 дугаар сарын 3-ны өдөр 328 дугаар тогтоол гаргаж Дорноговь аймгийн Хар-Айраг суманд хайлуур жонш гаргах, Төв аймгийн Баян сумын Мааньт өртөөний дэргэд шохой гаргах, боловсруулах үйлдвэрүүд байгуулахаар заасан байна. Ингэж ЗХБ-ын үйлдвэрлэлийн төрөлд уул уурхайн үйлдвэрлэл шинээр нэмэгдсэн түүхтэй.

Сайд нарын Зөвлөлөөс 1967 оны 4 дүгээр сарын 12-нд “Засан хүмүүжүүлэх байгууллагын ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 98 дугаар тогтоол гаргаж ЗХБ-ын үйлдвэрлэлийг: а/ уул уурхай, б/

¹⁵⁴ БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар гарсан хууль эрхийн баримт бичгийн эмхтгэл. УБ. 1991. 15-19 дэх талд нийтлэгдсэн.

шохойн чулуу олборлох, боловсруулах,

в/ тоосгоны, г/ мод бэлтгэлийн аж ахуй, д/ модны үйлдвэр, е/ зоорийн барилга гэсэн чиглэлүүдээр хөгжүүлбэл зохихыг заажээ.

БНМАУ-ын анхдугаар таван жилийн /1947-1952/ төлөвлөгөөний сүүлийн жил, хоёрдугаар таван жилийн төлөвлөгөөний /1959-1967/ эхний жилээс эхлэн Засан хүмүүжүүлэх байгууллага улсын төлөвлөгөөтэй ажиллаж түүнийгээ тоо, чанарын хувьд давуулан биелүүлж ирсэн түүхэн баримт олон бий.

МАХН-ын Төв хорооны 1980 оны 206, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн мөн оны 413 дугаар тогтоолын заалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж зохиогдсон олон ажлын үр дүнд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын үйлдвэрлэлийн байршил нилээд тогтвортой болж зарим анги колоныг олон дахин нүүлгэдэг, үйлдвэрлэлийн чиглэлийг өөрчилдөг байсан буруу практикийг багасгах, таслан зогсоох нааштай хандлага бий болсон байна.

Хоригдлын дунд зарласан хөдөлмөрийн уралдааныг эрчимжүүлэх гол хэлбэр бол тэдний хөдөлмөрийг үнэлэн ажлын хоногоор шагнаж, эдлэх ялаас нь хасч тооцох явдал байв. Энэ ажил улам боловсронгуй болж, олныг хамарсан өргөн цар хүрээтэй зохиогдож ирснийг харуулах зарим жишээг дурьдвал:

ЗСБНХУ байгуулагдсаны 60 жилийн ой угтсан хөдөлмөрийн уралдаанд өндөр амжилт үзүүлсэн 2173 хоригдлыг ЗХБУГ-ын даргын 1972 оны 12 дугаар сарын 27-ны 998 тоот тушаалаар 30-60 хоногоор шагнасны дотор 43 хүнд "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудыг удирдах газрын тэргүүний хүмүүжигч" гэрчилгээ олгож, хүн тус бүрийг ажлын 90 хоногоор шагнаж байжээ. Мөн газрын даргын 1986 оны 12 дугаар сарын 30-ны А/239 тоот тушаалаар 3145 хоригдлыг ажлын 3-60 хоногоор шагнасан байна. Энэ мэтээр хоригдлыг ажлын хоногоор шагнах явдал нилээд хавтгайрч Улсын Прокурорын газрын 1989 оны мэдэгдэлд шүүмжлэгдэж байсан удаатай.

ЗХБ-ын үйлдвэрлэл, хөдөлмөр зохион байгуулалтанд хамаарагдах өөр нэг зүйл бол хоригдлын хөдөлмөрийн хөлс төлөлтийн асуудал байдаг.

1931 оны хуулийн 30 дугаар зүйлд зааснаар хоригдлыг цалинжуулах, ингэхдээ хөдөлмөрийн хөлсний 25 хувийг өөрт нь олгох, 25 хувийг улсын санд тушаах, 50 хувийг засан сайжруулах газрын үйлдвэрийг өргөжүүлэхэд зориулан үлдээдэг журамтай байв. Хожим нь СнЗ-ийн 1956 оны 1 дүгээр сарын 30-ны 33 дугаар тогтоолоор хоригдолд шимтгэл олгох болсон байна. Тухайлбал өдөр тутмын хийсэн ажлын тодорхой хэмжээ тогтоож болох хэсгийг хувиар, бусад ахуй үйлчилгээний зэрэг ажлыг "онц" "сайн", "үүргээ сайн биелүүлсэн" гэсэн үнэлгээгээр тооцон, өдөрт дундаар 80 мөнгөнөөс

3 төгрөгийн шимтгэл олгож байв. Энэ байдал 1966 оны хуульд уламжлал болон тусгагдсан юм. Харин 1981, 1993, 1996, 2002 оны хуулиудад хоригдлын хөдөлмөрийг хийсэн ажлын тоо, чанарт тохирсон үнэлгээг бармтлан цалинжуулж байхаар заажээ.

Хоригдлын хөдөлмөр зохион байгуулалттай холбогдуулан тэмдэглэвэл зохих зарим онцлог зүйл байдаг. Улсын прокурор зөвшөөрч, НАХЯ-ны сайдын 1983 онд баталсан "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын дотоод журам"-д зааснаар ялтан хэдийгээр эзэмшсэн мэргэжилтэй байлаа ч тэднийг ажиллуулж болохгүй зарим ажил, албан тушаалууд байжээ. Энэ байдал нь дараа дараачийн холбогдох хуулиудад тусгагдан батлагдсан байдаг.

Харин нарийн мэргэжил бүхий хоригдлыг ЗХБ-ын зарим үйлдвэрт инженер, мастераар, түүгээр ч үл барам нягтлан бодогч, Хөдөлмөрийн тоо бүртгэлийн ажилд ажиллуулж байсны жишээ бол МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч даргаар ажиллаж байсан Т.Рагчаа гуай хоригдол байхдаа нягтлан бодогчоор ажиллаж байснаа сонины сурвлаглагчид дурсан ярьсан явдал юм.

Хоригдлыг бусад байгууллагад гэрээгээр ажиллуулах явдал 60-аад оноос нийлээд зохион байгуулалтанд оржээ. Тухайлбал, СнЗ-ийн шийдвэрийн дагуу Дулаанхаан, Шивэрмандал, Бороо-Сүжигтийн алтны уурхай, Горхи ба Толгойтын гүүрэнд 30-150 хоригдол ажиллуулж, 700 мянган төгрөгийн ажил хийлгэсэн тухай ХБУГ-ын 1987 оны тайланд тусгагдсан байна.

Хэдийгээр хоригдлыг гэрээгээр ажиллуулах тохиолдол цөөн байсан ч тасралтгүй явж ирсэний жишээ олныг дурдаж болно.

Ер нь хоригдлыг ажлын байраар хангах асуудал 80-аад оны сүүлч, 90-ээд оны эхэн үеэс эрс буурснаар олон сөрөг үзэгдэл гарах болсоныг ЗХБ-ын 70 жилийн ойд зориулан газрын дарга, хурандаа Ж.Чойндонгийн тавьсан илтгэлд тэмдэглэсэн байдаг.¹⁵⁵

Одоо ЗХБУГ-ын үйлдвэрлэлийн бие даасан салбаруудын он дараалалын хөгжлийн түүхээс маш товч байдлаар хэдэн баримт дурьдвал,

Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэл

Засан хүмүүжүүлэх байгууллагын барилга үйлдвэрлэлийн ажлын эхлэл нилээд дээр үеэс улбаатай. Эхний үед хоригдол барилгачид зөвхөн ЗХБ-ын өөрийн хэрэгцээний хоригдлын байр, ахуй үйлчилгээний жижиг цэг салбарын барилгыг барьдаг байжээ.

30-аад оноос улсын чанартай томоохон барилга байгууламжуудыг барьж эхэлсэн байна. Нийслэл

¹⁵⁵ А.Лхагва, Д.Даваа-Очир. Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ.2011 он. 448-449 дахь тал

Улаанбаатар хотын эх нялхсын төвийн дэргэдэх хүүхдийн 1-р эмнэлэгийн барилгыг хоригдлын хүчээр 1931-1932 онд барьсан тухай түүхэн материалд тэмдэглэсэн байдаг.

40, 50-иад оноос барилга байгууламж барихад хоригдлын хүчийг ашиглах ажиллагаанд зохион байгуулалтын хэд хэдэн өөрчлөлт оруулсан байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв хороо 1950 оны 5 дугаар сарын 26-ны өдөр “Барилгын хэрэг эрхлэх ерөнхий газрын харьяа барилгууд дээр хөдөлмөрийн бүтээжийг дээшлүүлэх, барилгын ажлын чанарыг сайжруулах арга хэмжээний тухай” 121/25 дугаар тогтоол гаргаж олон чухал арга хэмжээ авахаар заасны дотор барилга барих ажилд ажиллаж байгаа хоригдол ажилчдын тоог 4000-д хүргэхийг ДЯЯ-ны сайд Дүйнхоржавт даалгажээ.

Хоригдлын хүчээр Засгийн газрын барилга /хожмын Улсын багшийн их сургууль/, нэгдүгээр 10 жилийн дунд сургууль, гяндангийн барилга /хожмоо арьс өнгөний больниц байсан/, ДЯЯ-ны контор, эмнэлгийн барилгуудыг барьж, Сүхбаатарын талбайн тохижилт, Налайх-Улаанбаатарын нарийн төмөр замын зарим хэсгийг барьж байгуулсан байна. Жанжин Д.Сүхбаатарын хөшөөг хоригдол (лам) Сономын Чоймбол урлаж бүтээсэн¹⁵⁶ түүхтэй.

ЗХБ-ын Барилгын материалын үйлдвэрлэл 50,60-аад онд үе шаттайгаар өргөжин Гачууртад чулуу, тоосгоны, Дорноговьд альбастерийн үйлдвэр, Туул голоор сал урсган мод бэлтгэх ажлууд ихээхэн өрнөлттэй явж иржээ. Мөн Бугантын колоныхон 40-50 мянган шоометр гуаланг Ерөө голоор урсуулан тууж Дулаанхааны мод дамжуулах баазад хүргэж байсан баримт бий.

Дээр дурьдсан байдлаас үзэхэд Монгол улсын барилга, хот байгуулалтын түүхэнд хорих байгууллага томоохон байр эзлэх учиртай төдийгүй зарим тохиолдолд бүр анхдагч болохыг харуулж байна.

СнЗ-өөс 1960 онд гаргасан 86 дугаар тогтоолд ЗХБ-ын үйлдвэрлэлийн гол чиглэл нь мод бэлтгэл болохыг тэмдэглээд, мөн мод бэлтгэх төлөвлөгөөг 100 мянган шоометрээр нэмэгдүүлэх, Бэрлэг, Ялбагт жилдээ 50-80 мянган шоометр мод бэлтгэх, түүнчлэн Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сум, Хэнтий, Завхан аймагт мод бэлтгэлийн анги байгуулахыг заажээ. Мөн шаардагдах барилгын модон материалын захиалгыг жил бүр гарган НАХЯ-нд өгч байхыг Өвөрхангай, Өмнөговь, Баянхонгор, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Завхан зэрэг аймгийн АДХГ захиргааны дарга нарт үүрэг болгов. Энэ байдал нь манай улсын нутгийн баруун, зүүн хэсэг, өмнө талын зарим барилга үйлдвэрлэлд шаардагдах модон материалыг ЗХБ бэлдэх үүрэг авч, түүнийгээ хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын асар их ажил хийгдсэнийг харуулж байна.

Зөвхөн мод бэлтгэл, боловсруулалтын ажлыг дагнан хариуцахаар 60-аад онд Бугант, Ерөө, 70-80-аад онд Бат-Өлзийт, Хархорин, Бэрлэг, Мөнгөнморьт, Багануур зэрэг анги колонуудыг шинээр байгуулан ажиллуулж иржээ.

1970-аад оноос БНХАУ-д гуалин, ЗХУ-д жонш, зүсмэл материал, гуалин нийлүүлж байлаа. Экспортын төлөвлөгөөг биелүүлэхэд СнЗ, Гадаад худалдааны Яам болон НАХЯ-ны удирдлага ихээхэн анхаарч байсны дүнд 1970-1981 оны төлөвлөгөө 100,0-108,0 хувиар биелэгдэж, жилд 27-35 мянган мЗ гуалин, 40000 тонн жонш экспортолж байв.

Энэ хэдэн тооны цаана гэхэд л хэд хичнээн хүн хөдөлмөрлөж, ямар их бүтээлч ажил өрнөж байсан нь тодорхой байна.

Уул уурхайн үйлдвэрлэл

40-өөд оны сүүлчээр Бороод, 50-иад онд Цагаанчулуутад хоригдлын хүчээр алт олборлох болсноор ЗХБ-ын уул уурхайн үйлдвэрлэлийн түүх эхэлдэг.

Алт олборлолтын онцгой лагерь 1950 оны алт гаргах төлөвлөгөөг 109,3 хувиар биелүүлж системийн уралдаанд 1-р байр эзэлж байснаас үзэхэд тэр үед улсын санд ямар их хувь нэмэр оруулж байсан нь тодорхой.

1951 онд 50 кг алт олборлож, төлөвлөгөөг 304 хувиар биелүүлж байсан тухай тэр үеийн Бороогийн онцгой лагерьт улс төрийн орлогчоор ажиллаж байсан ахмад ажилтан, (Одоо генерал) О.Отгонжаргал гуай “Алтны Балжинням”¹⁵⁷ дурсамжиндаа тэмдэглэн өгүүлсэн байдаг.

БНМАУ-ын СнЗ-өөс 1968 онд “Их хайрханы вольфрамын үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 436, 1969 онд “Гялтгануурын орд газар ашиглах тухай” 290, 1982 онд “Авдарантын ордыг ашиглах зарим арга хэмжээний тухай” 313 дугаар тогтоолуудыг гаргаж, хэрэгжүүлэх өргөн цар хүрээтэй ажил зохиогдож байжээ.

50-иад оноос ЗХБ-ын эрхлэх уул уурхайн үйлдвэрлэлийн хүрээ өсч хэд хэдэн газар нүүрс, чулуу, жонш олборлох үйлдвэрүүдийг нэмэн байгуулсан байна. Тухайлбал БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1954 онд Налайхад, 1969 онд Ховдын Ганц модонд нүүрсний, 1963 онд Мааньтад шохойн, Хар-Айрагт жоншны хүдэр гаргах, 1964 онд Дундговь аймгийн Цагаан-Овоо суманд альбастрин, түүнчлэн Гачууртад чулуу олборлох, 1968 онд Харчулуутад гянтан /гянт болд/, 1969 онд Ховд аймгийн Үенч сумын Бодончид гялтгануурын, 1971 онд Дорноговь аймгийн Хажуу-Улаанд жонш олборлох, 1982 онд Авдарантад боржин чулууны үйлдвэр эрхлэх үүрэг бүхий анги, колониуд шинээр байгуулагдан үр дүнтэй ажиллаж ирсэн юм.

Ер нь 40-өөд онд алт олборлон эх орны мөнгөн

¹⁵⁶ А.Лхагва, Д.Даваа-Очир. Мөн бүтээл, УБ.2011он. 165-166 дахь тал

¹⁵⁷ “Эрх зүй, албаны мэдээлэл” сэтгүүл. 2001 он. № 3,4. 52-58 дахь тал

тэмдэгтийн баталгааг нэмэгдүүлсэн, 60-аад оноос хойд, урьд хоёр хөршдөө хайлуур жонш, зүсмэл модон материал, гуалин экспортлож эхлэн вальютын эх үүсвэрийн өсөлтөнд хүч боломжийнхоо хирээр тусалсан байгууллага Монгол Улсад ЗХБ-аас өөр хэд хичнээн байдаг бол гэсэн асуулт аяндаа гарч байгаа юм. Тэгвэл Засан хүмүүжүүлэх байгууллага Ү, Ү1 таван жилд /1970-1980 хүртэл/ экспортод гуалин, зүсмэл материал, жонш зэрэг 118,0-142,2 сая төгрөгийн бүтээгдэхүүн нийлүүлж байсныг одоогийнхтой харьцуулвал олон арав, зуугаар тоологдох тэрбум төгрөг гэсэн үг.

Бусад үйлдвэрлэлийн чиглэл

Засан хүмүүжүүлэх байгууллагын бусад үйлдвэрлэлд оёдол, гар урлал, мужаан дархан, мал аж ахуй, газар тариалангийн ажлыг хамааруулан авч үзэж байна.

Эхлээд гяндангийн дэргэд, дараа нь Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагерьүүд (ЗХҮЛ) ба Хориг ангиудыг удирдах газрын (ХАУГ) төвийн лагерийн харъяанд зөөлөн оёдол, гутал, гар урлал, арьс нэхий элдэх жижиг үйлдвэр-цех байгуулагдан ажиллаж байжээ. Чамин хийцтэй гутал, нохой дах, дэгтий болон гар урлалын өвөрмөц гоёмсог бүтээгдэхүүнийг нэгэн үе хорихынхон л үйлдвэрлэдэг байсныг мэдэх хүн олон.

Засан хүмүүжүүлэх байгууллага 1940 оноос Увс, Булган, Хэнтий, Сэлэнгэ аймгийн нутагт томоохон хэмжээний газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэн, 30-аад оны үед Зүүнхараад гурилын тээрэм ажиллуулан ард түмний хэрэгцээнд гурил, архин завад спирит нийлүүлж байсан нь манай улсын газар тариалангийн үйлдвэрлэлийн эхлэл, зарим Сангийн аж ахуй байгуулагдах үндэс тавигдахад чухал нөлөө үзүүлсэн гэж үзэж болох талтай.

Мөн 60-аад онд Буйр нуурт загасны үйлдвэр ажиллаж байв.

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони бүр мал, гахай, шувуу үржүүлэх, төмс, хүнсний ногоо тариалах чиглэлээр туслах аж ахуй хөгжүүлэхэд ихээхэн анхаарч ажилласны дүнд ЗХХБ-ын системд 1988 оны эцэс гэхэд 42 орчим мянган толгой мал тоологдсоны дээр, 110 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж, улсын дундачаас доогуургүй хэмжээний ургац хураан авч байв.

Туслах аж ахуйг эрхлэн хөгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий албыг ЗХХБ-ыг удирдах газарт байгуулсан, колони дундын туслах аж ахуй байгуулах замаар олон жижиг аж ахуйг нэгтгэсэн зэрэг нь тухайн үед үр дүнгээ өгч байжээ. 1987 он гэхэд ЗХХБ ажилчин албан хаагчдынхаа хэрэгцээнд 350 тонн мах нийлүүлж, нийт хэрэгцээт махны 70 гаруй хувь, мөн ялсны хэрэгцээнд шаардагдах махны 24 хувийг өөрийн туслах аж ахуйгаас хангадаг болсон байна.

Тухайн үеийн нам, төрийн дээд байгууллагаас

даалгасан цаг үеийн чанартай, шахуу хугацаатай үүргийг биелүүлэхэд ЗХБ-ын удирдлага, офицер, ажилтнуудаас хоригдлын хүчийг дайчлан зөв зохион байгуулж, амжилттай ажиллаж ирсэн зарим нэг жишээг дурьдвал:

-БНМАУ-ын СнЗ, МАХН-ын Төв Хорооноос 1954 оны 3 дугаар сарын 13-нд "Ямаа самнах сам хийх тухай" 75/15 дугаар тогтоол гаргаж, 10000 ширхэг сам яаралтай хийхийг Засан сайжруулах газарт даалгажээ. Энэ даалгаврыг биелүүлэхтэй холбогдсон ажлыг ЗХҮЛ ба ХАУГ-ын даргын тушаалаар зохион байгуулж оёдлын үйлдвэрээр 7000, Төв хорихоор 3000 ширхэг самыг 4 дүгээр сарын 10-нд багтаан хийлгэсэн байна.

-1950 онд Солонгосын Ардын чөлөөлөх армид бэлэг болгохоор ЗХБ-ын үйлдвэрүүд бээлий 10000 хос, хөвөнтэй өмд, цамц 1500 хос, үстэй дээл 1000 ширхэгийг оёх даалгавар авч яаралтай биелүүлэх ажил зохиогдсон юм. Мөн 40 мянган ширхэг хонины арьсыг хоригдлын хүчээр халимлан угааж цэвэрлээд Аж үйлдвэрийн комбинатад өгч байжээ.

Эцэст нь тэмдэглэхэд Засан хүмүүжүүлэх байгууллагын үйлдвэрлэл, хөдөлмөр зохион байгуулалтын түүх бол Монгол Улсын үйлдвэржилт, бүтээн байгуулалтын түүхийн салшгүй нэгэн томоохон хэсэг байсан гэж дүгнэн үзэх нь шударга ёс, түүхэн үнэнд нийцэхсэн билээ.

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ахмад ажилтан, бэлтгэл хурандаа агсан Дэндэвийн Аварзэд гуай "Засан ер нь манай улсын үйлдвэр аж ахуйн бараг бүх салбарын эх үндсийг тавьсан юм шүү дээ. Тухайн үеийн үзэл суртлын явцуурлаас болоод, өөрөөр хэлбэл социализмын эдийн засгийн гол салдбаруудын суурийг засангийнхан тавьсан болчих гээд байсан тул энэ үнэнийг дурьддаггүй байсан юм. Энэ нь одоо ч үргэлжилсээр байгаа нь хармсалтай. Онон, Хараа, Ерөө, Жаргалант гээд газар тариалангийн САА-н тулгын чулууг засангийнхан тавьсан, гар үйлдвэрлэл эрхэлж, алт олборлож, байшин барилга сүндэрлүүлж мөн ч их зүйл бүтээсэн дээ" хэмээн өгүүлснийг түүхийн амьд гэрчийн няцаагдашгүй үнэн үг гэлтэй.¹⁵⁸

Хоригдлын хөдөлмөр зохион байгуулалтын уламжлал, сүүлийн үеийн шинэлэг хэлбэр, үр дүн, цаашид боловсронгуй болгох талаарх харьцуулсан судалгааг үргэлжлүүлэн хийх шаардлага тавигдсаар байгааг тэмдэглэх нь зүйтэй.

2. ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨРИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Хоригдлын хөдөлмөрийг зөвхөн төрөөс баталсан хуульд заасан чиглэл, нөхцөлд захируулан зохион байгуулах явдал ЗХБ-ын нэг чухал үүрэг байлаа.

Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн

¹⁵⁸ А.Лхагва, Д.Даваа-Очир. Мөн бүтээл. УБ.2011 он. 254 дэх тал.

ялтанг засан сайжруулах ажлын тухай хуульд (1931он)¹⁵⁹ “Хоригдогсдын дотроос ажил үйлдвэрийг хийж чадахыг нь эрх биш бүгдийг нь ажилд хэрэглэх бөгөөд уул хоригдогсодоос хэн аль нь ямар ажилд авьяастай, мэдэх чадах нь юу болох, тэдгээрээс урьд хийж байсан ажил ба биеийн эрүүл мэнд ямар болохыг хянан үзэж харгалзан гүйцэтгэвээс зохимой” хэмээн заажээ. Харин 1966, 1993 оны хуулиудад хоригдлыг албадан хөдөлмөрлүүлэх, 1981 оны хуульд хоригдол заавал хөдөлмөрлөх, 1996, 2002 оны хуульд ял эдлүүлэх байгууллага хоригдлыг хөдөлмөрөөр хангах үүрэгтэйг тус тус онцлон заасан байна.

Хуулийн дээрх заалтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр тухайн үеийн нам, төрийн дээд байгууллага, Дотоод яам, НАХЯ-наас болон Хөдөлмөр-нийгэм хангамжийн төв байгууллагаас олон арван тогтоол, тушаал, заавар гарч, тэдгээрийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулагдаж ирсэнийг энэхүү өгүүллийн эхний хэсэгт дурдсан билээ.

Монгол ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хуульд хөдөлмөр зохион байгуулалтын талаар хэд хэдэн заалт (16-19 дүгээр зүйл) орсны зарим нь одоо ч ач холбогдолтой хэвээр байгаа юм. Тухайлбал;

- Мөн хоригдлын ажлын хүчнийг хамгаалах ба амрах, ажил хийх цагийг тогтооход Хүчнээ үнэлэгчийн тухай хуулийн (одоогийн Хөдөлмөрийн хууль) 28, 42 хүртэлх хийгээд 50,60-р зүйлд хүчнийг хамгаалах хэргийг эрхлэх төв комитетоос дэлгэрүүлэн зарлах тогтоолуудыг баримтлаваас зохимой.
- Жирэмсэн болсоор 5 сар өнгөрсөн эмэгтэйчүүдийг тэдгээрийн зөвшөөрөлгүйгээр засан сайжруулах газраас гадагш ажилд томилж үл болохоос гадна төрүүлэхийн урьд, хожид 45 хоногийн дотор аливаа ажлаас бүр мөсөн чөлөөлнө.
- Хоригдогсдоос гүйцэтгэх ажлыг уул засан сайжруулах газрын дотор ба гадна хэмээн хоёр анги болгон хувиарлахын дээр уул дотоод ба гаднах ажлыг аж ахуйн ба ажил үйлдвэрийн гэж тус тус ялгаврлан гүйцэтгэнэ.
- Засан сайжруулах газруудын аливаа ажил үйлдвэр ба урлах, дархлах газруудад хууль ёсоор бусадтай гэрээ хэлэлцээрүүдийг байгуулах зэрэг эрхийг олговоос зохих Үүнд:

1/ Аж ахуйн ба аж үйлдвэрийн хэрэг явуулгад холбогдох аливаа үүрэг хариуцлага бүхий гэрээ хэлэлцээр зэргийг байгуулах,

2/ Аливаа ажил үйлдвэрт хэрэглэгдэх эд юмыг худалдан авах ба үйлдэн гаргасан юм зүйлүүдийг хувиарлах,

3/ Ажил үйлдвэрээ цааш нь хөгжүүлэхийн тулд улсын ба кооперативын (хоршоо) газруудаас мөнгө

зоос зэрэг зүйлүүдийг зээлдэн авах

- Засан сайжруулах газруудаас гүйцэтгэсэн ажлын хөлс зэргийн орлогын зүйл нь тус газрын өөрийн хөрөнгө болох бөгөөд түүнийг зохих газарт харилцах дансаар хадгалж чухам юунд зарцуулахыг тодорхойлох (1-4 чиглэлээр);

- Засан сайжруулах газрын албан хаагчаас хоригдогсдыг хувийн ажилд хэрэглэж үл болно гэхчилэн заасан байдаг.

БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн (1966 он)¹⁶⁰ 13,14-р зүйлд хоригдлын хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрлөх нөхцлийн талаар тусгайлан заажээ. Тухайлбал;

- Хорих ял шийтгүүлсэн этгээдийг засан хүмүүжүүлэх үндэс нь тэднээр нийгмийн тусгай хөдөлмөр албадан хийлгэх явдал мөн. Хорих ял эдэлж байгаа хөдөлмөрлөх чадвартай хүн бүр хөдөлмөрлөх үүрэгтэй.
- Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, гяндан, хүмүүжил-хөдөлмөрийн колонид ял эдэлж байгаа хөдөлмөрийн чадвартай бүх хүмүүсийн ажлын өдрийн хэмжээг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл тогтооно.
- Хөдөлмөрийн хортой нөхцөлд ажилладаг хоригдлуудад хөдөлмөрийн хуулийн дагуу хорогдуулсан цагтай ажлын өдөр тогтооно. Хоригдол нь амралтын ба баяр ёслолын өдөр амрана. Хорих газруудад хоригдол этгээдийн хөдөлмөрийг БНМАУ-ын хөдөлмөрийн хуулиар тогтоосон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникийн дүрмийн дагуу зохион байгуулна гэж хуульчилсан байна.
- Харин хүмүүжил-хөдөлмөрийн колонид буй хоригдлууд Ерөнхий боловсролын сургалтанд хамрагдан суралцах бөгөөд сургалтын ажлыг нийгмийн тусгай хөдөлмөртэй заавал холбож явуулна. Хүмүүжил-хөдөлмөрийн колонид байгаа хоригдлууд техник мэргэжлийн сургалтын программаар ажлын мэргэжилд суралцах, мэргэжлээ дээшлүүлэх үүрэгтэйг заажээ.

Мөн насанд хүрээгүй хоригдлыг ажиллуулахдаа 14-16 насны хүмүүст 4 цагийн ажлын өдөр, 16-аас дээш насны хүмүүст хэрэв тэд өдөрт 4 цагаас доошгүй хичээллэж байгаа бол 5 цагийн ажлын өдөр, хичээл хийгээгүй буюу хийж байгаа боловч тэр нь 4 цагаас илүүгүй үргэлжилдэг бол 6 цагийн ажлын өдөр тогтооно гэж хуульчилсан байдаг.

Энэ хуулийн нэг онцлог бол тухайн төрөл дэглэмийн колонид ял эдэлж байгаа хоригдлын хөдөлмөрийг үнэлэхэд урамшууллын гол хэлбэр болгож ажлын хоног олгож, эдэлсэн ялд нь тооцох тухай тодорхой заасан явдал юм. Энэ байдлыг дэглэм тус бүрээр тодорхойлон заасан байдаг.

1966 оны хуульд хоригдлын хөдөлмөрийн хөлсний талаар тусгайлан заагаагүй ч энэ асуудал

¹⁵⁹ Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж (эмхтгэсэн: А.Лхагва, редактор П.Хосбаяр). УБ.2013. 11-33 дахь талд нийтлэгдсэн.

¹⁶⁰ Мөн эмхтгэл. УБ.2013 он. 43-65 дахь талд нийтлэгдсэн

БНМАУ-ын СнЗ-ийн 1950 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан журам зэргээр зохицуулагдаж байв.

БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн (1981 он)¹⁶¹ 35-37 дугаар зүйлд ялтныг хөдөлмөрт оролцуулах (35), тэдний хөдөлмөрийн нөхцөл (36), ялтны хөдөлмөрийн хөлс, түүнээс суутгал хийх (37,38), мөн ялтныг хөлсгүй ажилуулах (39) талаар заасан байна.

Дээрх зүйлүүдийн агуулгын зарим онцлог гэвэл,

- а/ Зохион байгуулалтын тухайд,
 - ЗХХБ-ын үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаа нь ялтныг засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх үндсэн зорилгод захирагдаж байх ёстой
 - Ялтан бүр заавал хөдөлмөрлөх үүрэгтэй
 - ЗХХБ-ын захиргаа нь ялтны хөдөлмөрийн чадвар, мэргэжлийг харгалзан нийгмийн тустай хөдөлмөрөөр хангах үүрэгтэй
 - Онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид ял эдэлж байгаа ялтныг хүнд ажилд ажилуулбал зохино.

б/ Хөдөлмөрийн нөхцөл,

- Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, гянданд ял эдэлж байгаа ялтны ажлын өдрийг 8 цагаар тогтоож, тэдэнд 7 хоног бүр нэг өдрийн амралт олгоно. Зайлшгүй шаардлагатай үед ялтныг илүү цагаар ажиллуулах журмыг БНМАУ-ын хууль тогтоомжоор тогтооно. БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан журмын дагуу баяр ёслолын өдрүүдэд ялтныг ажлаас чөлөөлнө. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд амралт, баяр ёслолын өдрүүдэд ялтныг ажилуулбал амралтыг нэг сарын дотор нөхөн олгоно.
 - Хүмүүжил хөдөлмөрийн колонид ял эдэлж байгаа ялтны ажлын өдрийн үргэлжлэл, түүнчлэн долоо хоног бүрийн амралтын өдрийг БНМАУ-ын хөдөлмөрийн хууль тогтоомжийг баримтлан тогтооно.
 - Хорих ял эдэлж байгаа этгээд нь ял эдлэх хугацаандаа ээлжийн амралт авах эрхгүй.
 - Хорих ял эдэлсэн хугацааг улсад ажилласан хугацаанд тооцохгүй.
 - Ялтны хөдөлмөрийг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникийн дүрмийн шаардлагын дагуу зохион байгуулна.
- в/ Хорих ял эдэлж байгаа ялтанд хөдөлмөрийн хөлс олгох, суутгал хийх
- Хорих ял эдэлж байгаа ялтны хөдөлмөрийн хөлсийг улс ардын аж ахуйн салбаруудад мөрдөж байгаа тарифын сүлжил, тарифт цалин, норм, үнэлгээг баримтлан хийсэн ажлын тоо, чанарт нь тохируулан олгоно. Ялтны хөдөлмөрийн хөлснөөс түүний хангамж, үйлчилгээний зардлын заримыг суутгана.
 - Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, гянданд хорих ял эдэлж байгаа ялтны хөдөлмөрийн

¹⁶¹ Мөн эмхтгэл. УБ. 2013 он. 65-118 дахь талд нийтлэгдсэн.

хөлснөөс ажлын тусгай хувцас, тусгай хоолны үнээс бусад хоол хүнсний болон хувцас, цагаан хэрэглэлийн үнийг суутгана. Хөдөлмөрийн хөлснөөс энэ суутгалыг хийсний дараа гүйцэтгэх хуудас болон бусад гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд заасан журмын дагуу суутгал хийх тухай заажээ.

Монгол Улс ардчилал, шинэчлэлийн замаар хөгжих болсон үеийн гарааны жил болох 1993 онд Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль¹⁶² батлагдсан гарав. Тухайн хуульд өмнөхөөс ялгагдах хэд хэдэн дэвшилттэй тал байв. Үүнд;

Нэгд, Төвлөрсөн буюу бүсчилсэн хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг тогтоох, тэдгээрийг ажлаар хангах асуудлыг Засгийн газар хариуцан шийдвэрлэх,

Хоёрт, Аймаг, нийслэлийн харъяалалтай хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг тогтоох, ажлаар хангах асуудлыг тухайн орон нутгийн засаг дарга хариуцан шийдвэрлэж байх.

Гуравт: Хоригдлыг хорих байгууллагын өөрийн үйлдвэрлэл, хорих байгууллагын хувь нийлүүлсэн болон хамтарсан аж ахуй нэгж, гэрээний үндсэн дээр урьдчилан хорих байрны аж ахуйн үйлчилгээ, бусад аж ахуй нэгжид хөдөлмөрлүүлж болох тухай заасан явдал юм.

Энэ хуулийн хоригдлын хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн нөхцөл, цалингийн талаарх заалтууд нь 1996, 2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад¹⁶³ үндсэндээ зарчмын өөрчлөлтгүйгээр тусгагдсан нь харьцуулсан судалгаанаас харагдаж байна.

3. ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ЦААШИД БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД ЧИГЛЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын хорих ял эдлүүлэх байгууллагад ял эдлэгсдийн хөдөлмөр зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын 90 гаруй жилийн түүхэн байдалд харьцуулсан судалгаа хийсний үр дүнд тулгуурлан дараах **дүгнэлт** хийж байна. Үүнд:

- Хорих ял эдлэгсдийг (ХЯЭ) хөдөлмөрт хамруулах ажиллагаа нь тэднийг хүмүүжүүлэх зорилгод чиглэгдэн, нэг талаар эдийн засгийн, нөгөө талаар эрүүл мэндийн ач холбогдолыг агуулж ирсэн байна. 1990 оноос өмнөх тогтолцооны үед “БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль” “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага” гэж нэрлэж ирсэн нь хөдөлмөр-хүмүүжлийн ажлын нягт уялдааг хангах нэг илэрхийлэл байсны бодит жишээ юм.
- Хорих ял эдэлж суллагдагсдын дотороос хэд хэдэн хүн БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, ардын

¹⁶² 1. Мөн эмхтгэл. УБ. 2013. 119-141 дэх талд нийтлэгдсэн.

¹⁶³ Мөн эмхтгэл. УБ. 2013 он. 164-207, 238-316 дахь талд тус тус нийтлэгдсэн.

болон гавъяат цолтон, төрийн шагналтан, Улсын хөдөлмөрийн аварга тариаланч, механикжуулагч, салбарын тэргүүний ажилтан (боловсрол, соёлын) гэх мэт алдартнууд төрсөн нь ЗХХБ-д зохиогдож байсан хөдөлмөр-сургалт, хүмүүжлийн ажил, энэ чиглэлээр ажиллаж ирсэн олон арав, зуугаар тоологдох офицер, албан хаагчдын уйгагүй хөдөлмөрийн үр дүн мөн.

- ЗХТБ нь 1953-1989 онуудад Улсаас өгсөн хатуу төлөвлөгөөт ажлыг хугацаанд нь тоо, чанарын хувьд биелүүлэх, давуулан биелүүлэхэд бүхий л хүч бололцоогоо дайчлан ажиллаж, зохих үр дүнд хүрч ирсэнийг олон түүхэн баримт харуулж байна.

80-аад оны сүүлч гэхэд ЗХХБ хөрөнгө оруулалтаас бусад бүх зардлаа орлогоороо нөхөөд, 19-23 сая төгрөгийг цэвэр ашгийн хэлбэрээр улсад тушаадаг байсаныг одоогийн байдалтай харьцуулахад байдал 180 градус болж, өөрөөр хэлвэл ухралт хийж өөрчлөгдсөн байна.

- Монгол Улсын Ерөнхийлөгч асан Нацагийн Багабанди Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын удирдах ажилтануудтай уулзаж хэлсэн үгэндээ: "Хорих ангиудын эрхлэн уламжлагдаж ирсэн үйлдвэрлэлийг сэргээх талаар зохих арга хэмжээ авч, хоригдлын 60 хувийг ажлын байраар хангасан нь нааштай үзүүлэлт юм гэж дурьдаад "Ялтныг хөдөлмөрлүүлэх асуудалд онцгой анхаарцгаа. Ялтны эрхэлж буй хөдөлмөр нийгэмд тустай, өөрсдөд нь хэрэгтэй, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь зах зээл болон дотоод хэрэгцээнд эрэлттэй байхаар зохион байгуулбал зохилтой. Ажил хөдөлмөрийг үзэн ядах, залхаах хашраах байдалд хүргэлгүйгээр эрхлүүлж, хорих ял эдлэгсдийг иргэний амьдралд шилжихэд бэлдэх, мэргэшүүлж дадлагажуулахад чиглэвэл нийгэмд ч, хувь хүндээ ч хэрэгтэй болно" хэмээн тэмдэглэсэн билээ. Энэ нь цаашид хоригдлын хөдөлмөрийг зохион байгуулахад баримталвал зохих үндсэн чиглэл, зарчим болж байна.

- Хорих ял эдлэгсдийн хөдөлмөр зохион байгуулалт, хөлс төлөлтийн талаар 1931, 1966, 1981 оны хуулиудад нилээд онцлог, дэвшилттэй байдлаар тусгагдсан байна. Харин 1993, 1996, 2002 оны хуулиудад дээрх хуулиудын холбогдох заалтууд үндсэндээ адил агуулагатайгаар хуульчлагдажээ гэсэн дүгнэлт хийж байна.

Өөрийн судалгааны ажилд тулгуурлан хорих ял эдлэгсдийн хөдөлмөр зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг цаашид улам боловсронгуй болгоход тус нэмэр болгох зорилгоор дор дурьдсан **саналыг** дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрт тусгагдсан; а/ ялтныг ажлын байраар хангах асуудлыг тодорхой үе шаттайгаар шинэ шатанд гаргах,

б/ гэмт хэргийн улмаас учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, в/ хорих байгууллагын дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэхээс гадна ялтны хөдөлмөрийг улс орны бүтээн байгуулалтанд түлхүү оролцуулах замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, г/ хорих байгууллагын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зах зээлийн нөхцөлд уялдуулан өргөжүүлэх замаар төрийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах чиглэлээр холбогдох судалгаа хийх ажлыг ШШГЕГ, ХСИС-ийн ШУТГ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн хамтын ажиллагааны хүрээнд хийж, бодлогын түвшинд боловсруулах ажил-асуудалд тус нөлөө үзүүлэхүйц зөвлөмж боловсруулах;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн "Ялтанд хийсэн хөдөлмөрийн тоо, чанарт тохирсон хөлс олгоно" гэсэн заалт бүрэн утгаараа хэрэгжихгүй зөрчигдөн, хорих ял эдлэгсдийн олонхыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж байгаа одоогийн практикийг өөрчлөхтэй холбогдсон заалтыг шинээр боловсруулж буй хуулийн төсөлд тусгах;
3. Монгол Улсын барилгажилт, хот байгуулалтын түүхэнд хорих, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн болон ШШГБ-ын оруулсан хувь нэмрийн талаар олон нийтэд суртачлах ажил зохиох нь зүйтэй. Энэ ажлыг ирэх 2015 онд 50 жилийнхээ ойг тэмдэглэх хорих 421-р ангийн барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн жишээн дээр зохион байгуулж болох юм.
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан (134.2) Хорих ангийн даргын эрхийг өргөтгөх замаар ялтанд улирал тутамд олгох ажлын хоногийн тоог нэмэгдүүлэх талаар шинээр гарах хуульд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.